



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/248

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 1-ний хугацаанд хэрэгжүүлэх "COVID19 нийгэм эдийн засгийн нөлөөлөл-Инноваци шингэсэн хариу арга хэмжээ" төслийг хамтран зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг ханган, улирал бүр хэрэгжүүлсэн ажлыг аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (А.Нарантуяа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010690

Аймгийн Засаг даргын 2020 оны 09-р сарын 16-ны өдрийн 148 дугаар захирамжийн хавсралт

“COVID19 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ - ИННОВАЦ ШИНГЭСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ” ТӨСЛИЙГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Нарийн бичгийн дарга Г.Хишигдаваа (Хөдөлмөр, Нийгмийн халамжийн үйлчилгээний газрын дарга)
- Гишүүд: Б.Саруулцэцэг (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга)
- Ц.Бадамцэрэн (Эрдэнэдалай сумын Засаг даргын орлогч)
- Б.Энхтуяа (Статистикийн хэлтсийн дарга)
- Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)
- А.Мөнхтуяа (Боловсрол, соёл урлагын газрын дарга)
- Б.Сайхантуяа (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
- Ц.Сугир (Аймгийн ахмадын хорооны дарга)
- Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
- Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)
- Б.Пэрэнлэймаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн сум хариуцсан мэргэжилтэн)
- Д.Цэвэлмаа (Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн)
- Б.Цэрэнням (Онцгой байдлын газрын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Н.Ууганбат (Сайнцагаан сумын 5-р багийн нийгмийн ажилтан)
- П.Ганчимэг (Сайнцагаан сумын 6-р багийн нийгмийн ажилтан)
- У.Оюунцэцэг (Сайнцагаан сумын 7-р багийн нийгмийн ажилтан)
- Н.Насанбаяр (Сайнцагаан сумын 8-р багийн нийгмийн ажилтан)
- П.Ууганцэрэн (Сайнцагаан сумын 9-р багийн нийгмийн ажилтан)
- Б.Амарсайхан (Эрдэнэдалай сумын хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Т.Бямбацэнд (Эрдэнэдалай сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн)